

Манай оронд 1921 онд мандсан ардын хувьсгалын нэн чухал үр дүн бол Монгол улсын тусгаар тогтнолыг сэргээн тунхагласан явдал мөн. Тэр цагаас Монголын ард түмэн туурга тусгаар орны нөхцөлд улс гэрээ засан төвхнүүлж үндэсний болон нийгмийн дэвшлийн ээдрээтэй, өвөрмөц замаар замнасан билээ. Харин дэлхийн тавцан дээр олон улсын эрхзүйн этгээдийн хувьд Монгол улс байр сууриа эзэлж чадалгүй хэдэн арван жил болсны уг сурвалж нь юуны өмнө тус улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх явдал багагүй зөрчил бэрхшээлтэй тулгарсанд оршино. Монгол хүний сэтгэлийг эмзэглүүлсэн энэ асуудал Монголын шинэ үеийн түүхийг сонирхогч, судлагч нарын анхаарлыг ямагт татсаар ирсэн юм. БНМАУ-ын гадаад бодлого, гадаад харилцааны сэдвийг дөчөөд жилийн тэртээ сонгон, хуримталж эхэлсэн баримт сэлтийг тухайн үеийн улс төр, үзэл суртлын баримтлалын улмаас эрдэм шинжилгээний ажлын эргэлтэд тэр бүр оруулах боломжгүй байсныг дашрамд өчсүгэй. Түүхэн үнэн, ил тод байдлыг эрхэмлэж буй өөрчлөлт шинэчлэлтийн өнөөгийн нөхцөлд эл сэдвийг ул суурьтай судлахыг эрмэлзэгчдийн бүтээл туурвилд тус дэм үзүүлэхийн үүднээс доорх баримт материалыг цуврал болгон нийтлэв.

**Түүхийн ухааны доктор
Б. Лхамсүрэн**

1. Монгол улсын тусгаар тогтносон тухай гадаад олон улсуудад тунхагласан бичгээс (1921 оны 9 дүгээр сар)

...Манай Монголын ард олноор үнэхээр тэсэхүйеэ бэрх болсон учир даруй ардын намын журамт цэргийг элсэн хуруулж нэгэнтээгүүр Орос улсын Зөвлөлт Засгийн газар мэдэгдэж, хоёр этгээдээс хүчин хавсран муу хулгай барон Унгерний зандалчин цэргээс их дундуурыг хядан арилгаж, дараачаар нийслэл Хүрээгээ эзлэн аваад, харьяат газар орон ба дотоод, гадаадын хүн иргэнийг батлан хамгаалах, одоо цагийн байдалд нийлүүлэн Богд хаан эзнээ хэвээр ширээнээ залж, ардын эрхтэй хэмжээт цаазат Засгийн газар байгуулан, дотоод засгийн элдэв хэргийг тэгшлэн засаж барон Унгерний харьяат зугтан зайлсан хоршоо хулгай нарыг сурвалжлан олж хядан арилгахаар цэрэг ангийг хуваан довтолгон мордуулсан нь манай Монголын хязгаарын дотор удахгүй улмаар энх төвшин болох биз ээ...

Одоо манай ардын засгийн газраас ер Дундад улстай өшөө хорслыг агуулан байлдах, дайтах хэргийг явуулах саналгүй боловч Хятадын суверенитетийг дахин хүлээж хэрхэвч чадахгүй ганцхүү одоогийн байгуулсан ардын эрхтэй хэмжээт засгийг өөрөө эзэрхэн явуулж, Дундад, Монгол эртнээс харилцан найралдаж худалдаа арилжааг нэвтрүүлэн Дундад, Монголын хүн иргэнийг тус тусдаа энх төвшний улиралд хандуулахыг гүнээ эрмэлзсэн бүхийн дээр, бас ч олон улстай гэрээ байгуулан худалдаа арилжааг нэгэн адилаар эрмэлзэн байгаа ба Орос улсын Зөвлөлийн Засгийн газраас урьдын императорын эзэрхэг засгийн

үед монгол Засгийн газартай тогтоосон олон зүйлийн эзэрхэг гэрээ бичгийг бүрнээ устгаж үүнээс хойш олон улстай нэгэн адилаар худалдаа нэвтрүүлнэ гэж дараа удаагаар батлан ирүүлсэн явдлыг хамтад илэрхийлэн гаргав.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл. I боть, 7—8 дугаар тал.

2. Монгол Ардын Засгийн газраас Зөвлөлт Оросын гадаад хэргийг эрхлэх ардын комиссариатад явуулсан нотоос (1921 оны 9 дүгээр сарын 10)

...Монгол Ардын Засгийн газрын тушаасныг дагаж, Зөвлөлийн засагт Их Орос Улсын Ардын эрхэм комиссар танаа Монгол улсын гадаад олон улстай эв найрамдал ба худалдааны гэрээ байгуулан, энгийн бат барилдлагыг илрүүлж ёсоор явуулах хэрэгт хөндлөн этгээд болон зуучлан оролцож тусламж үзүүлнэ үү гэж гуйн мэдүүлэхээс гадна эрхэм комиссар танаа мэдэгдэн толилуулах нь, одоо Монгол улсын олон түмэн ард өөртөө эзэрхэх эрхийг эгүүлэн авахад гаднын харгисыг байлдан сөнөөж, орон нутгаа цэвэрлэн арилгаж баатар зоригтой, ардын цэргийн сүрийг үзүүлэн тусгаар тогтнох бүрэн эрхтэй улс болох эрх чадлаа хэдийгээр дэлхий дахины олон улсын нүдний өмнө илрүүлсэн боловч Монгол, Хятадын хоорондын найрамдлыг байгуулан, хоёр улсын албан хэргийг харилцан нэвтрүүлэх явдал одоо хүртэл илрээгүй бүхий нь гэмшилтэйгээр үл барам, ийнхүү шалтгаанаас болж, манай монгол газар бүхий гадаад дотоод хүчнийг энх төвшний улиралд хандуулан Монгол, Дундад, Орос гурван этгээдийн ардад нэгэн адил ашиг тус, бүх олон улстай худалдаа нэвтрүүлэх аливаа хэргийг журамлан ёсоор явуулахд бэрхтэй болсон явдлыг хамтад илэрхийлэн гаргаад, Дундад улсын түмэн ард ба тэдний Засгийн газраас Монголын ард түмнийг өөрийн мэдэлд эзэрхэн хурааж, манай улсын дэвсгэр газрыг түрэмгийлэн эзлэх санааг хэрхэвч агуулахгүй гэж итгэж бас эрхэм комиссар таны сануулсныг хүндэтгэн хөндлөн этгээд болон зуучлан туслах явдлыг зөвшөөрэн хүлээх биз ээ гэж итгэж, үүний тулд эрхэм танаас яаравчлан хариу ирүүлэхийг эрмэлзэн байгааг илэрхийлэн явуулав.

Монгол Ардын Засгийн газрын ерөнхий
сайд бөгөөд Гадаад хэргийн яамны тэр-
гүүн сайд **Бодоо**

«Уриа» сонин. 1921, № 4.

3. Зөвлөлт Орос Улсын Засгийн газраас Монгол Ардын Засгийн газарт хариу ирүүлсэн нотоос (1921 оны 9 дүгээр сарын 21)

...Орос Засгийн газар танай хувьсгалт Ардын Засгийн газраас манай олон түмэн ба Зөвлөлийн Засгийн газарт найрамдлыг илтгэн, эрхэм таны бичигт итгэмжийг батлан ирснийг мэдэж ихэд баясав. Оросын засгийн газраас Монголын хувьсгалт засгийн газрын Хятадтай найрамдал, аливаа хэргийн учир харилцан нэвтрэлцэхтэй хамт тус улсын язгуурын чөлөө эрхийг батлах гэснийг машид зөвшөөрөөд энэхүү хэргийг дав дуваар бүрэн бүтэн болгохыг итгэмжлэн, манай Орос Засгийн газраас Хятадын Засгийн газарт шууд нэвтрүүлснээс гадна Хятад улстай харилцан нэвтрэлцэж бүхий Алс Дорнодын бүгд найрамдах улсын төлөөлөгчөөр уламжлан энэхүү хэргийн учир хэлэлцээ эхлэхийг Хятадын Засгийн газарт сануулсан болой. Одоо ойрноос орос Засгийн газар Хятадтай худалдааны гэрээ байгуулахын тулд тусгай төлөөлөгчийг явуулж ургэлжид харилцан нэвтрэлцэхийг эрмэлзсээр буй бөгөөд Монголын хувьсгалт Ардын Засгийн газрын 1921 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн бичигт манай Засгийн газрыг Монгол Хятад хоёрын хоо-

ронд зуучилна уу гэснийг Оросын Засгийн газар баясан хүлээв. Бас Монголын ард ба Засгийн газар Хятадын бүгд найрамдах улстай эвдрэлийг цээрлэн энэхүү зуучлах явдлыг Хятадын Засгийн газраас сайшаан хүлээнэ гэж манай Засгийн газар итгэмжилнэ.

Зөвлөлийн Засагт Холбоот бөгөөд Ний-
гэм журамт Бүгд Найрамдах Орос Улсын
гадаад хэргийн ардын комиссар
Георгий Чичерин

«Уриа». 1921 оны 9 дүгээр сарын 21.

4. Монгол Ардын Засгийн газраас Америкийн Нэгдсэн Улсын Гадаад яаманд явуулсан нотоос (1921 оны 9 дүгээр сарын 12)

...Америк улсын гадаад хэргийн яамны эрхэм сайд танаа амгаланг эрэхээс гадна Европын 1919 дүгээр оноос эхлэн 1921 дүгээр оны 7 сар хүртэл манай Монгол автономит засгийн эрхийг булаагдан, ард олноор туйлын гашуун зовлонг эдэлсэн ба одоо нэгэнт Хятадын харгис цэрэг ба Оросын муу хулгай барон Унгерний зандалчин цэргийн хорлолоос ангижирч, Богд хаан эзнээ хэвээр ширээнээ залж, ардын эрхтэй засгийн газар байгуулан, улсын дотоод хэргийг сайжруулан засаж, гадаадтай найрамдахыг эрмэлзэж бүхий элдэв учрыг сая нэгэнт тунхаглан зарласан тул эрхэм сайд та ба эрхэм улсын Засгийн газар хийгээд ард олноор толилсон биз ээ. Одоо гагцхүү тусгайлан илтгэх нь манай Богд хаан ба Засгийн газар хийгээд олны санал бол эрхэм улсын засгийн газраас манай Монголын ардын засгийн газартай эртхэнээ гэрээ байгуулан, элчин сайд суулгаж худалдаа арилжааг улмаар бадруулан хоёр этгээдийн ашиг тусыг хөгжүүлэхийг хүсэж байгаа тул эрхэм сайд та толилж даруйхнаа баяртай хариу хүртээх ажаамуу.

Монгол улсын Ардын Засгийн газрын
ерөнхий сайд, Гадаад хэргийн яамны
тэргүүн сайд **Бодоо**

БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл. I боть, 6 дугаар тал.

5. Монгол, Орос хоёрын хоорондох найрамдлын барилдлагаг байгуулах тухай Монгол Ардын Засгийн газар ба Зөвлөлийн засагт Орос улсын Засгийн газрын хэлэлцэн тогтоосон гэрээ бичгээс (1921 оны 11 дүгээр сарын 5)

Нэгдүгээр зүйл. Зөвлөлийн засагт Орос улсын Засгийн газраас гагцхүү хуулийн ёсоор эрх барьсан Монгол Ардын Засгийн газрыг зөвшөөрөн хүлээв.

Дөрөвдүгээр зүйл. Зөвлөлийн засагт Орос улсын Засгийн газраас Монгол улсын нийслэл Хүрээнд бүрэн эрх барих төлөөний элчин ба Улиастай, Ховд, Алтанбулаг хотын газар тус тус консул суулгана. Бас Монголын Ардын Засгийн газартай зөвлөн хэлэлцэж бусад газар суулгаж болно.

Тавдугаар зүйл. Монгол Ардын Засгийн газраас Зөвлөлийн засагт Орос улсын нийслэлд бүрэн эрх барих төлөөний элчин суулгаж болно. Бас Зөвлөлийн засагт Орос улсын Засгийн газартай зөвлөн хэлэлцэж хилийн ойрх олон мужуудад консул суулгаж болно.

Зургадугаар зүйл. Орос, Монголын зах нийлсэн улсын хил хязгаарыг хоёр этгээдийн засгийн газраас дараа зөвлөн хэлэлцэж тусгай комисс байгуулан тогтооно.

БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл.
I боть, 31—32 дугаар тал.

6. Хятадын Гадаад яамны сайд Ян Хуэй-Цинтэй Зөвлөлт Орос улсын бүрэн эрхт төлөөлөгч А. К. Пайкесын хийсэн ярианаас (1921 оны 12 дугаар сар)

Монголоос Зөвлөлтийн цэргийг хэзээ гаргах вэ гэж Ян Хуэй-Цин асуухад Пайкес, Зөвлөлт Орос улс Монголын хувьд эзэрхэн түрэмгийлэх бодлого огт үгүй. Цагааны зандалчид Бээжингийн Засгийн газрын өөгшүүлснээр Зөвлөлт Оросын аюулгүй байдалд заналхийлж байсны улмаас Гадаад Монголд Зөвлөлтийн цэргийг арга буюу оруулсан бөгөөд тэрхүү аюул заналыг арилгах бодтой баталгаатай болсон цагт өөрийн цэргийг гаргах болно гэдгийг мэдэгджээ. Мөн Ян Хуэй-Цинд Зөвлөлтийн төлөөлөгч, Монголын Засгийн газраас Хятадтай хэлэлцээ хийхэд зуучлах хүсэлтийг Зөвлөлтийн Засгийн газарт тавьсныг мэдэгдсэн байна. Гадаад Монгол, Хятадын хоорондын харилцааг зохицуулахад Зөвлөлт Засгийн газар бэлэн байна гэж Пайкесын хэлэхэд Ян Хуэй-Цин уул саналыг хүлээж авсангүй.

М. С. Капица. Советско-китайские отношения. М., 1958, с.72.

7. Хятад дахь ЗСБНХУ-ын төлөөлөгчөөс Хятадын төв Засгийн газрын төлөөлөгч Ли Юанд өгсөн нотоос (1922 оны 2 дугаар сарын 7)

...Зөвлөлт Засгийн газар Монголд эзлэн түрэмгийлэх гэсэн санаа огт үгүй. Харин Монголд цагааны дээрэмчдийг бут цохиж энх төвшин байдлыг сахиулахын тулд Монголын Засгийн газрын хүсэлтээр Зөвлөлтийн цэргийг түр оруулсан учраас Монголын Ардын Засгийн газартай Бээжингийн Засгийн газар хэлэлцэн тохирч харилцаагаа зохицуулах цагийг тэсгэлгүй хүлээж байна.

Документы внешней политики СССР. М., 1961, т.5, с.86.

8. Нийслэл хүрээнд 1922 оны 1 дүгээр сард Өвөр Монголын ноёдын төлөөлөгчид хүрэлцэн ирж, Монголын гадаад бодлогыг эрхлэн явуулах ба хил хязгаарыг хамгаалах эрхийг Хятадын мэдэлд шилжүүлэх тухай Бээжингийн Засгийн газрын саналыг уламжилжээ. Мөн оны 1 дүгээр сарын 24-нд Засгийн газрын хуралдаанаар уул саналыг хэрэгсэхгүй болгож Зөвлөлт Орос Улстай гэрээ байгуулсан тухай болон Монгол-Хятадын хооронд ЗОУ зуучлахыг зөвшөөрсөн тухай дурдаж, Бээжинд төлөөлөгчөө явуулах шаардлагагүй гэж үзэж байгааг хариу мэдэгджээ.

Монголын түүхийн төв архив, Ф.1, т.6, Х.Н. — 24.

А. Пайкес

9. Монголын Гадаад явдлын яамнаас Зөвлөлт Оросын элчин төлөөлөгчид явуулсан нотоос (1922 оны 5 дугаар сарын 23)

Богд хааны зарлиг, ойрноос сонсвоос Хятадын зэрэг гадаадын сонин бичигт миний биеийг Монгол газар бүхий орос цэргийг татан буцаалгаж, хятад цэргийг ирүүлэх ба монгол газрыг Хятадын муж болгохыг гуйн Хятадын Засгийн газраа бичиг мэдүүлжээ гэх зэргийн үгс буй хэмээмой. Энэ болбоос огт худал цуу үг болой. Миний бие гагцхүү , одоогийн байгуулсан ардын эрхтэй улсын засгийг үүрд батлан хамгаалахыг гол зорилт болгон бас ч Зөвлөлийн засагт Орос улсын Засгийн газраас Монгол-Хятадын хооронд зуучлан хэлэлцэж эртхэнээс найрамдлын гэрээ бичиг хэлэлцэн тогтоолгож хоёр этгээдийн хүмүүн иргэнийг амаржуулахыг гүнээ эрмэлзэн бүхийгээс өөр үгүй болох явдлыг дотоод гадаадад нийтээр зарлан ухуулагтун хэмээснийг хичээнгүйлэн дагаж, үүнийг Зөвлөлийн засагт Орос улсын Гадаад хэргийн яамнаас Монгол газар суугаа орлосон төлөөлөгч Охтин танаа мэдтүгэй хэмээн явуулав.

Улсын архив Ф.1, т.26, х.н. —2.

10. Монгол улсын Ардын Засгийн газрын гадаад явдлын яамны бичгээс (1922 оны 9 дүгээр сарын 11)

...Манай Ардын Засгийн газраас Хятад, Монгол хоёр улсын хооронд зуучлан хэлэлцэж найрамдлын гэрээ бичиг тогтоолгон хоёр этгээдийн хүмүүн иргэнийг эртхэнээ энх төвшний улиралд дэвшүүлнэ үү хэмээн Зөвлөлийн засагт Орос улсын Засгийн газраа дараа удаа цахилгаан мэдээ ба албаны бичгээр гуйсанд мөнхүү засгийн газраас зөвшөөрөн хүлээж Орос, Хятад хоёр улсын хоорондын элдэв хэргийг хэлэлцэн тогтоолгохоор томилсон төлөөлөгчид тушааж хамтатган хэлэлцүүлсүгэй хэмээсэн ба мөнхүү Төлөөлөгч нар Хятадын нийслэл Бээжинд хүрч одооноос хойш хагас жил илүү болсон боловч зуучлан хэлэлцсэн хэрэг хэрхэн болж бүхий лавтай мэдээг манай Ардын Засгийн газар хараахан олж мэдээгүй бөгөөд эртхэнээс зуучлан хэлэлцэж манай Ардын Засгийн газрыг даруй түргэнээ батлан тогтоолгож ард түмнийг амаржуулахыг гүнээ эрмэлзэн бүхийн тул үүнийг эрхэм бүрэн эрх барих элчин сайд танд мэдтүгэй хэмээн явуулаад, олдвоос байцаан толилж уламжлан эрхэм улсын Засгийн газар ба Хятадын нийслэлд бүхий төлөөлөгч нарт цахилгаанаар нэвтрүүлэн бас ч хэрхэн болж бүхий учир байдлыг даруйхнаа хариу ирүүлэх ажаамуу.

Намын төв архив. Ф.1, т.2, Х.Н. — 18, 35-36 дугаар тал.

11. Хятадын Гадаад явдлын яамны 1922 оны 9 дүгээр сарын 25-ны меморандум болон түүнд Зөвлөлт Оросын төлөөлөгчийн өгсөн хариугаас

Хятадын меморандумд Монголын гаалийн газраас хятад худалдаачдыг хавчсан хэмээх гомдол гаргаж Монголоос улаан цэргийн ангиудыг даруй гаргах шаардлагыг Зөвлөлт-Хятадын хэлэлцээ эхлэхийн нөхцөл болгон тавьжээ.

Мөн оны 10 дугаар сарын 14-нд Зөвлөлт Оросын төлөөлөгч А. А. Иоффегээс өгсөн хариу нотод хэлэлцвэл зохих иж бүрэн зүйлийн дотроос Монголын асуудлыг сугалан авч үл болохыг дурдаад Монголд Зөвлөлтийн цэргийг оруулсны шалтгаан, Зөвлөлт Орос улсад цагаантны заналхийлэл арилаагүй байгааг тайлбарлаж, Зөвлөлтийн цэргийг даруй гаргах нь Оросын сонирхлын үүднээс бололцоогүйгээр үл барам Хятадын ард түмний жинхэнэ ашиг сонирхолд харшилна. Монгол дахь хятад худалдаачдын гомдлын тухайд гэвэл тус улсын доторх дүрэм журмыг Зөвлөлтийн цэргийн командлал бус, харин Монголын засаг захиргаа тогтоодог тул тийнхүү гомдол гаргах нь эндүүрэл болжээ гэсэн байв.

М. С. Капица. Советско-китайские отношения. с. 89-90.

12. Зөвлөлт Орос улсын элчин Любарскийд Монголын Гадаад явдлын яамнаас өгсөн нот бичгээс (1922 оны 11 дүгээр сарын 30)

Ойрноос гадаадын олон сонин бичигт Зөвлөлтийн засагт Орос улсын төлөөлөгч Бээжингийн газраа хүрч Монгол улсын өөртөө тогтносон хэргийг Хятадын Засгийн газар лугаа зуучлан хэлэлцэхэд урьдын гурван этгээдийн гэрээ бичгийг журамлан автономит эрхийг эдлүүлэхээр саналаа илтгэжээ гэх зэргийн үгс буй. Энэ нь элдэвлэвч манай Монгол улсад өөртөө эзэрхэх бүрэн эрхийг эдлүүлэхэд үл дурлах ба Зөвлөлийн засагт Орос, Ардын засагт Монгол хоёр улсын засгийн газар ба мөн хоёр этгээдийн олон түмэн ардын хооронд завсардуулахыг хичээсэн зальхай этгээдийн дэмий зохион тараасан худал үгс магад мөн. Тийн хэмээвч энэ хэр манай Монголын ард олноор ихэд хэрдхийн шүүмжлэлдэж буй тул үүнийг эрхэм элчин сайд танд мэдтүгэй хэмээн явуулаад олдвоос эл учрыг байцаан толилж уламжлан зохих газраа нэвтрүүлэн явуулж, эл учир ийм бус хэмээх явдлыг сонин бичгүүдэд

хэвлүүлэн тарааж, олны сэжиглэлийг устган бас ч хэрхэн шийтгэсэн явдлыг хариу ирүүлэх ажаамуу.

ГХТА. Ф.I, X.H. — 84, нуг. 413.

13. Зөвлөлт Орос улсын элчин Любарскийгээс ГЯЯ-нд ирүүлсэн хариу нот бичгээс (1923 оны 1 дүгээр сарын 23)

Эдүгээ Зөвлөлийн засагт Орос улсаас Хятад улсад суугаа бүрэн эрх барих тусгай төлөөний элчин нөхөр А. А. Иоффегийн биед өвчин тохиолдсоор нэлээд удсан учир Хятадын Засгийн газар лугаа нүүр тулж, энэ хэр харилцан хэлэлцсэн зүйл үгүй. Иймийн тул хоёр этгээдийн хэлэлцээнд нөхөр Иоффегээс ийн тийн хэлбэй хэмээх зэргээр сонин бичгүүд дор гаргасан нь сонин бичгийн хүмүүсийн санааны зоригоор зохиосон энгийн чимээ буй заа.

Бүрэн эрх барих төлөөний элчин Любарский

ГХТА. Ф., X.H. — 8⁴, нуг. 1208.

14. Доктор Сун Ятсен, Хятад дахь Оросын бүрэн эрхт төлөөлөгч А. А. Иоффегийн хамтарсан мэдэгдлээс (1923 оны 1 дүгээр сарын 26)

Өнөөгийн Оросын Засгийн газар Гадаад Монголд эзлэн түрэмгийлэх бодлого явуулах буюу түүнийг Хятадаас тусгаарлах зорилтыг огтхон ч тавиагүй гэж ноён Иоффе хатуу мэдэгдсэнд доктор Сун Ятсен сэтгэл бүрэн ханамжтай байна. Тийм учраас Оросын цэргийг гадаад Монголоос нэн даруй гаргахыг хойшлуулшгүй чухал буюу Хятадын сонирхолд нийцнэ гэж доктор Сун Ятсен үзэхгүй байна гэжээ.

China Year Book. 1924, 1863.

15. Зөвлөлт Холбоот Улсын ГЯЯ-наас Монголын ГЯЯ-нд элчин Даваагаар дамжуулан мэдэгдсэн нь (1923 оны 9 дүгээр сар)

Зөвлөлийн засагт Нийгэм журамт Холбоот улсын Гадаад яамны түшмэл Духовский харьяат яамны тэргүүн сайдын нэрээр уламжсан манай яамны зөвлөх түшмэл орлосон Сампилонд энэ 18-ны өдөр хэлсэн нь: Сайд Карахан Дундад улсын төлөөлөгч Ван лугаа учраад Гадаад Монгол өөртөө эзэрхэх эрхийг Дундад улсын хэмжээтэй эзэрхэх лүгээ хамт хүлээн авахаар хэлэлцээн нээхийг зөвшөөрөх буй заа хэмээн хэлсэн дор төлөөлөгч Ван Дундад улс Монголд өөртөө эзэрхэх эрх өгөхийг зөвшөөрөх буй хэмээжээ. Учир иймээс Дундад Монголын төлөөлөгч нар Бээжин хотонд чуулж хоёр улсын хэрэг хэлэлцэх болжээ. Орос улс болбаас Монгол Хятадын хооронд үг залгаж зуучлахаас бус хуралд суухгүй. Дундад улсын Засгийн газраас монгол нутагт орос улаан цэрэг бүхий цагт хэлэлцээн нээж үл болно хэмээн сайд Караханд мэдэгдсэн дор мөн сайд Карахан эл хэргийг Хятад Монгол хоёр этгээдийн хурал дээр хэлэлцэн шийтгэвээс зохино хэмээн хариу өгсөн нь Хятад хүлээхээр болжээ хэмээсэн ... арван есөн. Даваа гэснийг ГЯЯ-нд 13 оны 9 сарын 20-нд хүлээн авчээ.

ГХТА. Ф.I, X.H. – 89, нуг. 82.

16. Зөвлөлт Холбоот Улсын ГЯЯ-наас Монголын ГЯЯ-нд элчин Даваагаар дамжуулан мэдэгдсэн нь (1923 оны 9 дүгээр сар)

Орос улсын Гадаад яамны түшмэл Духовскийгээс мөн яамны тэргүүн сайдын нэрээр хэлсэн нь: манай Засгийн газраас нийслэл Хүрээнд суугаа төлөөлөгчөөр Монголын Засгийн газраа уламжлан мэдэгдэхээр цахилгаан мэдээгээр явуулсан хэргүүд нь: Нэг, Монгол Орос хоёр улсын хооронд найрамдал урьд хэвээр байна. Хоёр, Орос улс болбаас Хятад Монгол хоёрын хооронд зуучилж Монгол улсын өөртөө эзэрхэх

эрхийг батлуулахыг хүснэ. Гурав, монгол газраас орос цэрэг гаргах болбаас эл хэргийг Монгол улсын Засгийн газар лугаа сайтар хэлэлцэнэ. Дөрөв, Орос улс болбаас Монголыг хамгаалалгүйгээр үл орхино. Тав. Орос улсын элчин сайд нийслэл хүрээнд очсон даруй Орос Монголын хооронд дахь хэрэг илтгэн хэлэлцэнэ хэмээснийг сонсгов. Хорин гурван. Даваа гэснийг ГЯЯ-нд 13 оны 9 сарын 24-нд хүлээн авчээ.

ГХТА. Ф.I, х.н. --89, нуг, 83.

17. Монголын талаар Зөвлөлтийн төлөөлөгч Л. Караханы ярьсан зүйлээс (1923 оны 9 дүгээр сар)

Хятадын хэвлэлд: Карахан Бээжинд хүрэлцэн ирснийхээ дараахан Монгол нь зохих хэмжээний автономит эрхтэйгээр Хятадын суверенитетэд үлдвэл Монголын эрх ашиг илүү хамгаалагдана гэсэн санааг илэрхийлэв. Орос улс ингэж зохицуулахад саад үл хийх төдийгүй тус хоёр ард түмний харилцан ойлголцоход чадах бүхнийг хийх болно. Оросод дутагдаад байгаа зүйл Монголд байхгүй учир түүнийг өөртөө Нийлүүлэх гэсэн хүсэл Орос улсад огт үгүйгээс гадна тийнхүү нийлүүлэх нь бага буурай улс түмний өөртөө засахад туслах гэсэн Орос улсын нэгэнт тунхагласан эрмэлзэлд харш болно. Монголын нутаг дэвсгэрээс цагаантны довтолгоон гарахгүй байхыг Хятад улс баталгаатай болгосон цагт Орос улс өөрийн үлдсэн цэргийг гаргахад бэлэн байна гэж тэр хэлэв гэжээ.

China review. V, p. 111, okt, 1923.

18. Монгол-Хятадын харилцааны талаар Монголын тал баримталж байгаа байр сууриа илэрхийлсэн нь (1923 оны намрын адаг сар)

Энэ талаар Гадаад яамны сайд МАХН-ЫН III их хуралд илтгэхдээ хэлсэн нь: -

...Манай Монгол Ардын Засгийн газар ба олон түмэн ардууд Дун дад улсын хэмжээтэй эзэрхэх эрхийг дахин хүлээж хэрхэвч чадахгүй болсныг Орос улсын Засгийн газар нэн ч нэвтэрхийгээр толилсоор буй. Тийн атал сайд Карахан Дундад, Монголын хооронд зуучлан хэлэлцэхэд Дундад улсын төлөөлөгчид гадаад Монгол өөртөө эзэрхэх эрхийг Дундад улсын хэмжээтэй эзэрхэх лүгээ хамт хүлээн авахаар хэлэлцээ нээхийг зөвшөөрөх биз ээ гэж илтгэсэн хэмээхийг олж үзээд манай Ардын Засгийн газар ихэд хэрдхийн цочсон боловч энэ нь лав манай Монголын элчин сайдын газар ташааран ухсан буй заа хэмээн сана мой. Үүнд манай Ардын Засгийн газар болбаас Дундад улс лугаа эрт хэнээс найрамдаж, хоёр этгээдийн олон түмэн ард иргэдийг энх амраар аж төрөхийг хүсэх боловч гагцхүү Дундад улсын Засгийн газраас:

1. манай Монгол улсын бүрэн эрхтэй тусгаар тогтносон улс болсныг зөвшөөрөн хүлээх;

2. манай Монголын бүхий л хохирсон зүйлийг бүрнээ төлөн өгөх;

3. дотоод чуулганы зэрэг монгол овогтонд автономи эрх тус тус олгох;

4. Орос улсын төлөөлөгчийг хуралд гэрч болгон суулгаж хэлэлцэх

5. мөнхүү хэлэлцээт Хүрээнд нээхийг зөвшөөрөх аваас манай Ардын Засгийн газраас даруй бүрэн эрх барих төлөөлөгч нарыг томилон хэлэлцээн нээхийг зөвшөөрнө хэмээн уламжлан явуулсан бүлгээ.

«Ардын эрх». 1924 оны 8 дугаар сарын 27, № 22.

19. ЗХУ-ын гадаад хэргийн ардын комиссар Чичерингээс элчин Даваагаар дамжуулан мэдэгдсэн нь (1923 оны 11 дүгээр сар)

...Монголын Засгийн газраас саяхан мэдэгдсэн таван зүйл санал зүйтэй боловч Орос Монгол хоёр хоорондоо энэ мэт саналаа илтгэж

болох буй заа. Манай улс дөрвөн зуун сая Хятад лугаа найрамдахыг хусэх нь маш чухал болохын дээр тэрхүү таван саналыг баримталж Эдүгээ Хятад лугаа хэлэлцээн нээх хэмээвээс Хятад огт хүлээхгүй, уг хэрэг улам хойшлохоос гадна эл таван санал болбаас анх ардын намын төлөөлөгч нар лугаа Монголын гэрээ хийхээр хэлэлцсэн зүйлд огт нийлэлцэхгүй болжээ. Учир нь монгол газар Хятад цэрэг ба Оросын цагаан хулгай орсон цагт манай улс Монголын ардын намд тусламж хүргэж Хятад ба цагаан хулгайг Монголоос гаргаж ардын намд эрх олгоод эцэс дор Хятад Монгол хоёрын хооронд зуучилж Монгол улсыг дүүрэн эрхтэй автономит болгохоор хэлэлцсэн учрыг хорин нэгэн оны зуны цагт Монголоос Москва хотонд ирсэн Жамсаранд хэлсэн ба бас ч энэ жил зуны цаг Эринчиновт хэлсний дээр манай төлөөлөгч Шумяцкий бээр эл хэргийг анх явуулж байхдаа мөн тэр ёсоор Монгол нөхөд лүгээ хэлэлцэж байсан төдийгүй Монгол Ардын Засгийн газрыг тогтоод байхад тэргүүн сайд миний биеэс Бодоод мөн эл учрыг бичгээр мэдэгдэн явуулсан зүйл буй.

Болгар, Туркийн суверенитет дор байсан боловч гадаад улсууд лугаа харилцан найрамдах их эрхтэй байсан ба эдүгээ цагт Төвд мөн тэр мэт Хятадын суверенитетээс гарсангүй боловч Хятад дор захируулахгүй гадаад улс лугаа харилцаж буй тул Монгол улс Хятадын нэр хэмээсэн суверенитет эрхийг хүлээн аваад Төвд, Болгар мэт байдлаа төвшитгөвөөс зохих мэт. Гэвч Хятадын байдлыг үзэж байгаад Монгол улсын таван саналаас Хятадад хэлж болох цаг тохиолдваас тэр тухайд хэлэлцэж болох буй заа. Одоо эл хэргийн учрыг манай Карахан, танай Данзан хоёр түүгээр мэдэж байваас зохих тул манай газраас нөхөр Караханд танай таван зүйл саналыг явуулсугай хэмээсэн... арван найман. Даваа гэснийг ГЯЯ-нд 13 оны 11 сарын 19-нд хүлээн авчээ.

ГХТА Ф.I, х.н. —84, нуг. 97.

20. Хятадын төлөөлөгч Ван Жентина. Зөвлөлтийн төлөөлөгч Л. Караханы өгсөн нот бичгээс (1924 оны 1 дүгээр сарын 17)

...Монголын тухай асуудлыг бид хэрхэн үзэж байгаа нь тов тодорхой, үүнд бид Монголыг Хятадын хэсэг гэж үзэх бөгөөд Хятадын Засгийн газраас манай хил хязгаарын аюулгүй байдлыг сахиулах баталгаа өгсөн даруй Хүрээнээс улаан цэргийн ангиулыг гаргахад бэлэн байна... Танаас Монголын асуудлыг Зөвлөлт Засгийн газрын шударга эсэ хийн гэрч болгон тавьж байгаад би их харамсаж байна. Бидний хооронд чухамдаа энэ асуудлаар ноцтой зөрөлдөөн үгүй билээ. Орос-Хятадын найрамдлыг эсэргүүтэгчид Орос, Хятад хоёр улсын сайн харилцааг сэргээхэд саад хийхийн тулд Монголын асуудлыг шалтаг болгож байгаа учраас би машинд харамсаж байна гэжээ.

А. Ивин. Китай и Советский Союз. С предисловием Карахана. Госиздат. 1924, с. 119—120.

21. Зөвлөлт-Хятадын хэлэлцээрийн төслийг 1924 оны 3 дугаар сарын 14-нд Л. Карахан, Ван Жентин нар үзэглэсний дараа Хятадын талын нэмж засварлахаар санал болгосон зүйлийн дотор:

1. Орос улсаас гурав дахь этгээдтэй Хаант засгийн үед байгуулсан төдийгүй түүнээс хойш ч Хятадтай холбогдуулан байгуулсан гэрээ хэлэлцээрүүдийг хүчингүй болгох тухай заах.

2. Монголоос улаан цэргийн ангиудыг гаргах тухай заасан хэсэгт Монгол нь Хятадын суверенитетийн доор байна гэдгийг тодотгон засах тухай шаардлага гол суурийг эзэлж байв.

М.С. Капица. Советско-Китайские отношения. с. 112.

22. ЗСБНХУ, БН Хятад улсын хоорондын асуудлуудыг зохицуулах ерөнхий зарчмын тухай хэлэлцээрээс (1924 оны 5 дугаар сарын 31)

Тавдугаар зүйл. ЗСБНХУ нь Гадаад Монголыг Бүгд Найрамдах Хятад улсын бүрэлдэхүүн хэсэг гэж хүлээн зөвшөөрч Хятадын бүрэн эрхийг хүндэтгэнэ. Гадаад Монголоос ЗСБНХУ нь Орос улсын цэргийг татан авах тухай, тодруулбал, эдгээр цэргийг татах цаад талын хугацаа болон ЗСБНХУ-ын хил хязгаарыг аюулгүй байлгахын үүднээс авбал зохих арга хэмжээний тухай асуудлуудыг энэхүү хэлэлцээрийн хоёрдугаар зүйлд заасан бага хурлаар* шийдвэрлэмэгц ЗСБНХУ-ын Засгийн газар өөрийн цэргийг Гадаад Монголоос гаргах болно.

Документы внешней политики СССР. т.VI, с.

23. ЗСБНХУ-д Монголын хэргийг хамаарагч Гүрсэдээс «Известия» сонинь сурвалжлагчтай ярилцсан яриандаа Зөвлөлт, Хятадын хэлэлцээр байгуулсантай холбогдуулан хийсэн мэдэгдлээс (1924 оны 6 дугаар сар)

...Монгол-Хятадын харилцаа цаашид ямар замаар явахыг ганцхүү Монгол-Хятадын тусгай бага хурал тодорхойлж болох юм... Монгол-Хятадын хэлэлцээ эхлэх ахул Монголын Засгийн газар ба ард түмэн, харийн булаан эзлэгчидтэй тэмцэн хүнд хохирлын үнээр байлдан олсон тус орны өнөөгийн байдлыг хамгийн шургуугаар өмгөөлөн хамгаалах болно гэжээ.

«Известия». 1924 оны 6 дугаар сарын 27.

24. Зөвлөлт-Хятадын хэлэлцээр болон Монгол-Хятадын харилцааны талаар ерөнхий сайд Цэрэндоржийн хийсэн мэдэгдлээс (1924 оны 9 дүгээр сар)

Энэ жил зуны тэргүүн сард Орос, Дундад хоёр улс, хоёр этгээдийн засгийн газрыг харилцан зөвшөөрөн хүлээж хоёр улсын хоорондын аливаа хэрэг зүйлийг дараа хурал нээж хэлэлцэн тогтоохоор зөвшөөрөн их товчоог тогтоон баталсан ба түүний дотор бидний Монголын тухай мөн ч дурдсан зүйл буй боловч тэрхүү тогтоосон их товчоог Дундад иргэн улсын зүүн гурван мужийг эзэрхэн бүхий харгис түшмэл Жан Золин тэргүүлэн эсэргүүцсэн зэргээс саатагдан мөнхүү хурлыг эдүгээ хүртэл нээгээгүй ба Дундад улсын Засгийн газраас Дундад Монголын хоорондын хэргийг эртхэнээс хэлэлцэн тогтоовоос зохино хэмээн Монголын бүрэн эрх барих төлөөлөгчийг томилон Бээжинд ирүүлэх буюу эсэхүл Бээжингээс хүн томилон Хүрээнд илгээж зөвлөн хэлэлцсүгэй хэмээх зэрэг хүний нэр доор удаа дараа цахилгаан мэдээ ирсэн, хоёр засгийн нэрээр харилцвал зохих учрыг хариу цахилгаан мэдээ явуулсан ба одоо мөн явуулахыг завдан буй гэжээ.

«Хувьсгалт залуучуудын эвлэл» сэтгүүл. 1925, № 1. 49 дүгээр тал.

25. Улсын анхдугаар их хурлаар баталсан БНМАУ-ын Үндсэн хуулиас (1924 оны 11 дүгээр сар)

БНМАУ-ын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлд: Бүх Монгол улсыг үүнээс хойш Бүгд Найрамдах бүрэн эрхтэй ард улс гэж, улсын дээд эрхийг жинхэнэ ардад эзлүүлэн, улсын элдэв хэргийг улсын их хурал ба мөн хурлаар сонгогдсон Засгийн газраас шийтгүүлэх явдлыг нийтээр сүслэн дагаваас зохино.

Үндсэн хуулийн гуравдугаар зүйлийн 1-д: Монголын арван нэг дүгээр оны хувьсгалаас чинагш Монголын эрх баригчдын гадаадтай тогтоосон гэрээ бичгүүл ба мөнгө зээлдүүлсэн зүйлүүд бол гадаадаас хүчирхэн хүлээлгэсэн болох тул цөмийг устгасанд тооцно гэжээ.

Мөн гадаад улсуудтай харилцах, улс төрийн ба худалдааны гэрээ

*Зөвлөлт—Хятадын хэлэлцээрийн хоёрдугаар зүйлд хэлэлцээрт гарын үсэг зурснаас хойш нэгэн сарын дотор бага хурал зарлан хуралдуулж хэлэлцээрийн зүйлүүдэд дурдсан бүх асуудлын талаар тодорхой хэлэлцээрүүдийг боловсруулан гаргана гэж заасан байв.

бичиг тогтоох, концесс ба монополийн эрх олгох, өөрчлөх, устгах, улсын хил хязгаарыг өөрчлөх, байлдах, найрамдах, цэргийн хүчнийг байгуулах зэрэг явдлыг улсын дээд эрхийг барих газруудын эрхлэн шийтгэвэл зохих зүйлс мөн гэж хуульчлан тунхаглажээ.

Улсын анхдугаар их хурал ЗОУ-тай найрамдлын барилдлагаа тогтоох тухай 1921 оны гэрээг батлахын хамт Хятад улстай найрамдалт харилцаа тогтоох бодлоготой байгааг дахин нотолжээ. БНМАУ-ын их, бага хурлын тогтоол, Үндсэн хууль, Тунхгууд. 1956 он, 30-32 дугаар тал.

26. Монгол-Хятадын харилцааг зохицуулах асуудлаар ЗСБНХУ-ын гадаад хэргийн ардын комиссар Чичерин, БНМАУ-ын ерөнхий сайд Цэрэндорж нарын солилцсон утсаас (1924 оны 12 дугаар сар)

Чичеринээс Юдингээр дамжин ирсэн утсанд: Эдүгээ үед Хятадын дотоод байдал тогтнож шинэ гарч бүхий хүчнүүд учраа олохоос өмнө цагийн байдалд нийлүүлэн Монгол төлөөлөгч нарыг Хятадад томилон явуулж автономит эрхийг шууд шүүрэн авах явдлыг үүсгэвээс Монголын Засгийн газраас ямар хэмээн үзэхийг хүсжээ. Ерөнхий сайд Цэрэндоржийн хариу утсанд: Улсын Их Хурлаас нэгэнт манай Монгол улсыг бүрэн эрхтэй Бүгд Найрамдах Улс хэмээн баталсны дээр эдүгээгийн Дундад улсыг эзэрхэж бүхий харгисуудын занал нь хэтэрхий тул тэд нараас энэ үе автономийн эрхийг олох явдал их л бэрх мэт. Гэвч манай Монголоос Дундад улс лугаа харилцан хэлэлцэхийг үл татгалзана. Гагцхүү урьдаар Хятадаас бидний Монголыг хэрхэн үзэж бүхийг бидэнд ба Караханд сонсговоос уул хэрэгт тус болох болов уу гэхээс гадна эдүгээ манай Монголоос даруйхнаа албаны бус төлөөлөгчийг томилж Хятадын аливаа дотоод байдлыг хянуулан янагш мэдээ нэвтрүүлэх ба мөн Хятадын хувьсгалын этгээд лүгээ холбоо хэлхээ үүсгэвээс тустай мэт гэжээ.

НТА. Ф1, т. 3. х.н.-16. 57 дугаар тал.

27. БНМАУ-ын Бага хурлын дарга Гэндэн, ерөнхий сайд Цэрэндорж нараас РОСТА-ын сурвалжлагчтай ярилцахдаа хийсэн мэдэгдлээс 1925 оны 1 дүгээр сар)

Монгол улс бүрэн тусгаар тогтносон улс мөнийг Улсын Их Хурал дэлхий нийтийн өмнө дахин батлав. Монгол улс Зөвлөлт Орос улстай байгуулсан гэрээний үндсэн дээр найрамдалт харилцаа тогтоосон билээ.

Монголд Холбоот улсын элчин төлөөлөгч, Герман, Франц, Итали, Хятадад байгаагийн нэгэн адил сууж байна. Москвад Монголын элчин бүрэн эрхт улсын төлөөлөгчийн ёсоор сууж байна... Хятадын харгисууд Монголыг дагуулан захирахыг урьдын адил санаархах, эзлэн түрэмгийлэх шалтаг эрж Монголын дотоод байдал болон Холбоот улстай тогтоосон харилцааны тухай худал хуурамч мэдээг Бээжингээс дэлхий дахинд тарааж байна. Монголын ард түмэн Японы зар, Хятад генерал Сью Шужаны харгислалыг мартаагүй бөгөөд Монголын Засгийн газар өөрийн улсын тусгаар тогтнолыг соргогоор хамгаалж байна гэжээ.

«Известия Улан-Батор хото». 1925 оны 1 дүгээр сарын 18, № 148.

28. Монголоос Зөвлөлтийн цэргийг гаргасантай холбогдуулан Караханаас Хятадын Засгийн газарт өгсөн нотноос (1925 оны 4 дүгээр сар)

Зөвлөлт Засгийн газар Монголын Засгийн газартай тохиролцсоноор Гадаад Монголоос улаан армийн ангиудыг гаргаж, эдүгээ нэгэнт дууссаныг Хятадын Засгийн газарт мэдэглэж байна. Үүнийг сонордуулахын ялдамд Хятадын Засгийн газраас ЗСБНХУ-ын энэхүү нөхөрсөг алхмыг зохих ёсоор үнэлнэ гэж итгэж байна.

Үүний хамт Хятадын Засгийн газар, Монголын талтай найрсаар хэлэлцэн тохиролцоо замаар хоёр ард түмний харилцааны асуудлыг шийдвэрлэх тааламжтай завшааныг алдахгүй гэж гүнээ итгэж байгаагаа илэрхийлье. Энэхүү харилцааг гагцхүү Хятад, Монголын ард түмний хэрэг гэж ЗХУ-ын Засгийн газар үзэх боловч Хятад Монгол хоёр ард түмэн өөрсдийн үндэсний эрмэлзэл, шударга ёсны зарчим дээр ах дүү ёсоор найрсаг орших нь Гадаад Монгол ба Зүүн хойд Хятадын эдийн засгийг хөгжүүлэх, ЗХУ-тай тэдгээрийн эдийн засгийн болон бусад хэлхээ холбоог зузаатгахад тус дөхөм үзүүлнэ гэж ЗСБНХУ-ын Засгийн газар баяртай байх болно гэжээ.

«Известия Улан-Батор хото» 1925 оны 4 дүгээр сарын 9, № 170.
Үргэлжлэл бий.

Он цаг, тоо баримт

ХОЙД, ӨМНӨД СОЛОНГОС: ЭДИЙН ЗАСГИЙН ЯЛГАА

	Өмнөд Солонгос	Хойд Солонгос
1. Үндэсний нийт бүтээгдэхүүн /ҮНБ/ БНАСАУ-ын засгийн газрын мэдээгээр /1988 он/ 1 хүнд ногдох ҮНБ		2530 ам. доллар
Өмнөд Солонгосын “эх орноо нэгтгэх хорооны” мэдээгээр /1989 он/ ҮНБ	210 тэр бум ам доллар	21 тэрбум ам. доллар
1 хүнд ногдох ҮНБ Английн Олон улсын стратегийн хүрээлэнгийн тооцоогоор /1987 он/	4968 ам. доллар	987 ам. доллар
Дотоод нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл /ДНБ/	121,3 тэрбум ам. доллар	45,5 тэрбум ам доллар
2. ДНБ-ын бүтэц /%-аар/	Олборлох үйлдвэр 31,9 Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй 10,2 Бусад салбар 57,2 /1989 он/	Аж үйлдвэр, үйлчилгээний салбар 76,0 Хөдөө аж ахуй 24,0 /1981 он/
3. Санхүүгийн бүтэц: /1989/ Орлого	43 тэрбум ам. доллар	35,7 тэрбум ам доллар
Зарлага	42,3 тэрбум ам. доллар	35,7 тэрбум ам. доллар
4. Батлан хамгаалахад зориулах зардал /1989 он/ /Улсын нийт зардалд эзлэх хувийн жин, %-аар/	9,1 тэрбум ам доллар 21,6%	4,3 тэрбум ам. доллар 12,1%
5. Экспортын нийт хэмжээ	62,4 тэрбум ам. доллар /1989 он/	2 тэрбум ам. доллар /1988 он/
Түнш орнууд %	АНУ 35,3 Япон 19,8 Гонконг 5,9 ХБНГУ 3,9 Англи 3,2 Бусад орон 31,9	ЗХУ 52,6 Япон 19,4 Хятад 14,0 Азийн бусад орнууд 8,1 Баруун европ 3,9 Бусад орон 2,0